



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 08 өдөр

Дугаар A/61

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Цэнгэлдэх хүрээлэнгийн гадна цэвэр усны холболт”-ын ажлын зураг төсөв боловсруулах ажил “ДУОНӨГ/2017/00019/04”-ийн гүйцэтгэгчээр “Ар төгөл” ХХК”-ийг сонгон 4,724,500 /дөрвөн сая долоон зуун хорин дөрвөн мянга таван зуун мянга/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Зураг төсвийн ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Ар төгөл” ХХК –ний захирал /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, зураг төсвийн ажилд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0320172